



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/80

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.6, Засгийн газрын 2015 оны “Жагсаалт батлах тухай” 336 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт”-ын 8.8 дахь хэсэг, аймгийн Онцгой комиссын 2023 оны өргөтгөсөн 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Онцгой комиссын өргөтгөсөн хуралдаанаар өвөлжилтийн нөхцөл байдалд хийсэн үнэлгээгээр 14 сум эрсдэлийн түвшин их, 5 сум дунд эрсдэлтэй гарсан тул өвөлжилтийг хохирол багатай даван туулах зорилгоор гадны аймагт оторлоогүй үлдсэн малчин өрхүүдэд хямдралтай үнээр олгох өвсний үнийн зөрүү 97,800,000 (ерэн долоон сая найман зуун мянга) төгрөгийн зардлын хуваарилалтыг хавсралтаар баталсугай.

2. Өвс нийлүүлсэн аж ахуйн нэгж, иргэдтэй гэрээ байгуулж, өвс тэжээлийн чанар, баглаа боодол, гарал үүсэл зэрэгт хяналт тавьж, хуваарилалт хийж, гэрээ байгуулахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т үүрэг болгосугай.

3. Дээрх зардал болох 97,800,000 (ерэн долоон сая найман зуун мянга) төгрөгийг аймгийн гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0116

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны дугаар
сарын-ны өдрийн дугаар
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

д/д	Сумын нэр	Сумдад олгох өвсний тоо	Өвсний нэг бүрийн үнэ (мянган төгрөг)	Нийт үнэ (мянган төгрөг)	Өвс нийлүүлэх иргэн, аж ахуйн нэгжийн нэр
1	Баян-Өндөр	856	8.0	6848.0	Ж.Дорждэрэм
2	Баруунбаян-Улаан	535	8.0	4280.0	Э.Өсөхбаяр
3	Бат-Өлзий	688	8.0	5504.0	Б.Отгонбаяр
	Бат-Өлзий	800	8.0	6400.0	С.Пүрэвдорж
4	Бүрд	613	8.0	4904.0	Э.Өсөхбаяр
5	Өлзийт	540	8.0	4320.0	Б.Хорлоо
6	Зүүнбаян-Улаан	1192	8.0	9536.0	Ж.Түмэннасан
7	Есөнзүйл	686	8.0	5488.0	С.Баянмөнх
8	Хайрхандулаан	736	8.0	5888.0	ӨВ Түвшин хангай ХХК
9	Сант	802	8.0	6416.0	Э.Өсөхбаяр
10	Тарагт	961	8.0	7688.0	Д.Нолсон
11	Төгрөг	593	8.0	4744.0	ӨВ Түвшин хангай ХХК
12	Хархорин	1069	8.0	8552.0	Гучингийн хөсөг ХХК
13	Хужирт	1231	8.0	9848.0	Д.Батболд
14	Арвайхээр	923	8.0	7384.0	ӨВ Түвшин хангай ХХК
		12225		97800.0	